

Аюулгүй ирээдүйг хойч үедээ өвлүүлнэ.



Хүчирхийллийн эсрэг
үндэсний төв



ТАЙЛАН 2019

БИД

ХҮЧИРХИЙЛЛИЙН ДАВАН
ТУУЛАГЧДЫН ЭРХ,
ХЭРЭГЦЭЭНД СУУРИЛАН
ДАРААХ ҮЙЛЧИЛГЭЭГ
МЭРГЭЖЛИЙН ТҮВШИНД,
ЦОГЦООР ҮЗҮҮЛЖ БАЙНА.



Түр хамгаалан байрлуулах



Сэтгэл зүйн зөвлөгөө,
тусламж



Нийгмийн ажлын үйлчилгээ



Хүүхэд хамгаалал



Хууль зүйн зөвлөгөө, эрх
зүйн тусалцаа



Холбон зуучлах үйлчилгээ



Итгэлийн утас

Та гэр бүлийн
хүчирхийллээс урьдчилан
сэргийлэх, хүчирхийлэлтэй
тэмцэх үйл ажиллагаанд
хандив өргөхийг хүсвэл:

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

₮ 453019244

\$ 453033610

ҮНДСЭН ЗОРИЛГО

Хүн бүрийн аюулгүй, халдашгүй, хараат бус байх эрхийг
хангах болон хохирогчийг хамгаалах үр дүнтэй тогтолцоог
бий болгоход нөлөөлнө.



Хүчирхийллийн эсрэг

Үндэсний төв нь



Монгол Улсад анх удаа
эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг
үйлдэгдэж буй гэр бүлийн
хүчирхийлэл, бэлгийн
хүчирхийллийг эцэс болгох,
хохирогчийг хамгаалах
зорилгоор

**Ашгийн бус, аливаа
нам, улс төрийн хүчнээс
хараат бус, шашны урсгал
чиглэлээс ангид нийгэмд
үйлчилдэг ТББ.**

**1995 онд
байгуулагдсан.**

шууд үйлчилгээ, бодлогын
нөлөөллийг хослуулан ажилладаг.

11

Үндэсний хэмжээнд
салбар

2

Хамгаалах байр

1

Нэг цэгийн үйлчилгээний төв

5

Хөтөлбөр

1

Сургалт, зөвлөх
үйлчилгээний төв



Хүн бүрийн эрхэм
чанар, аюулгүй,
халдашгүй, хэнээс ч
хараат бус байх жам
ёсны эрхийг хангахын
төлөө

25 ДАХЬ ЖИЛДЭЭ

тууштай ажиллаж
байна.





Хүчирхийллийн эсрэг үндэсний төв нь 2019 оны үйл ажиллагааны тайлангаа Эрхэм танд толилуулж байгаадаа баяртай байна.

Манай төв нь байгуулагдсан цагаасаа эхлэн гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчдыг дахин хүчирхийлэлд өртөхөөс хамгаалах, тэдэнд цогц үйлчилгээ үзүүлэх, нийгэмд хүчирхийллийг үл тэвчих хандлагыг төлөвшүүлэх, гэр бүлийн хүчирхийлэлд үр дүнтэй хариу үйлдэл үзүүлэхэд мэргэжилтнүүдийг чадавхижуулах, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоход нөлөөлөх зэргээр хүн бүрийн гэр бүлдээ амар тайван, аюулгүй амьдрах суурь эрхийг баталгаажуулахын төлөө 25 жилийн турш ажиллаж ирсэн.

2019 онд бид нийслэл, орон нутагт шинээр байгуулагдсан хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх Нэг цэгийн үйлчилгээний төвийн мэргэжилтнүүдийг ажлын байранд дагалдуулан сургах, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэрэгжилтэд мониторинг хийх, хамтарсан багуудыг чадавхижуулах сургалт зохион байгуулах, нийслэлийн алслагдсан хороодын иргэдэд хүрч очих үйлчилгээ үзүүлэх г.м олон талт ажлуудыг амжилттай зохион байгууллаа.

Бидэнд итгэж зорин ирдэг үйлчлүүлэгчиддээ, цаг зав, мэдлэг туршлагаа харамгүй зориулдаг Удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн гишүүддээ болон нөр их хичээл зүтгэл гарган ажилласан хамт олондоо сайн сайхныг хүсье.

Санхүүгийн болон техник арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлж, хамтран ажиллаж буй санхүүжүүлэгч, хандивлагчид, бусад түншүүддээ гүн талархал илэрхийлье.

Аюулгүй ирээдүйн төлөөх бидний хамтын ажиллагаа өргөжинө гэдэгт итгэлтэй байна.

Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн захирал



Н.Арвинтариа

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд тайлан бэлтгэж илгээв.

Хүний эрхийн төрийн бус байгууллагуудын форумаас Хүний эрхийн төлөв байдлын ээлжит хэлэлцүүлгийн гурав дахь циклийн тайланг 2019 оны 10-р сард НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлд илгээсэн.



ХЭҮТ нь “Гэр бүлийн хүчирхийлэл” сэдвийн хүрээнд мэдээлэл цуглуулж, тайлан бэлтгэн хүргүүлээ.

ЦЕГ-ийн Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэстэй хамтын ажиллагааны “санамж бичиг” байгууллаа.

Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг түр хамгаалах, хохирогчид үйлчилгээ үзүүлж буй мэргэжилтнүүдийн аюулгүй байдлыг хангах,



харилцан суралцах, туршлага солилцох зорилгоор ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг х а м г а а л а х хэлтэстэй хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа.

Төрийн зарим чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэж байна.



Нийслэлийн Хөдөлмөр, Халамж үйлчилгээний газраас зарласан Түр байрлуулан асрамжлах үйлчилгээ үзүүлэх ТББ-ыг сонгон шалгаруулалтад шалгарч, Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргүүдийн зорилтот бүлгийн 145 иргэдэд үйлчилгээг үзүүллээ.

Олон улсын Нийгмийн үйлчилгээний глобал сүлжээ (ISS) байгууллагын гишүүнээр элслээ



ISS нь шилжилт хөдөлгөөний улмаас нийгмийн төвөгтэй асуудалтай тулгарсан хүүхэд, гэр бүлд туслах зорилгоор 1924 онд байгуулагдсан, дэлхийн 130 гаруй улс орнуудад төлөөлөгч, гишүүд, хамтрагч байгууллагуудтай олон улсын нийгмийн үйлчилгээний байгууллага юм.

ХЭҮТ нь 2008 оноос хойш хамтран ажиллаж ирсэн бөгөөд 2019 онд албан ёсоор гишүүнээр элслээ.

Дэлхийн итгэлийн утасны сүлжээнд нэгдэв


GLOBAL NETWORK OF WOMEN'S SHELTERS

NWS
Viola makes you feel safe. Everywhere.



THE HELPLINES PROJECT
CREATING A WORLD WIDE WOMEN'S SAFETY WEB

Бид гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийг давантуулагчдад туслах Дэлхийн Тусламжийн утасны сүлжээнд нэгдсэнээр дэлхийн улс орнуудаас холбогдсон гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчдод утсаар зөвлөгөө өгөх, холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх, харилцан туршлага солилцож, хамтран ажиллах боломжтой боллоо.



Дэлхийн хүн амын байдлын тайлан- 2019

Тус төвийн захирлаар 1997 оноос 2017 он хүртэл ажилласан, Удирдах зөвлөлийн гишүүн Д.Энхжаргал нь эмэгтэйчүүдийн эрхийн төлөө, гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тууштай тэмцэгч билээ. Түүний үйл хэрэг, тэмцлийн түүх нь 2019 оны Дэлхийн хүн амын байдлын тайлан (НҮБХАС)-д нийтлэгдлээ.

Хэн ч хөгжлөөс хоцрох ёсгүй! ТХЗ 2030


Байгууллагаас сүүлийн 3 жилд гаргасан дижитал мэдээлэл сурталчилгааны материалуудыг дохионы хэлээр хөрвүүлж, сонсголгүй иргэдэд хүргэж байна.



СУРГАЛТ → **245** хүн



МЭРГЭЖИЛТНҮҮДИЙГ
ЧАДАВХИЖУУЛАХ **630** хүн



МОНИТОРИНГ



ОРОН НУТАГ **7**
ДҮҮРЭГ **2**

СУРТАЛЧИЛГАА



ХҮРЧ ОЧИХ
ҮЙЛЧИЛГЭЭ **460** хүн

16 ХОНОГИЙН
АЯН **25.000** хүн

Аюулгүй ирээдүйг хойт үедээ өвлүүлнэ.

Эрх зүйн шинэчлэл хөтөлбөр

- ▶ Цагдаагийн алба хаагчийн чиг үүргийн хэрэгжилтэд хийсэн мониторингийн тайлан (2019)-д үндэслэн Зөрчлийн тухай хуулийн хариуцлагын төрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах саналын томьёолол боловсруулж Хууль зүй, дотоод хэргийн яам болон ажлын хэсэгт хүргүүллээ.
- ▶ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4 дэх хэсэг болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/73 дугаар тушаалаар батлагдсан “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, журам”-ын хэрэгжилтийн байдалд мониторинг хийлээ. Мониторингийн мэдээллийг 10 аймаг, 2 дүүргийн Цагдаагийн хэлтсийн Баривчлах байр, ШШГЕГ-ын 5 хорих анги, баривчлах төвөөс цуглуулж, мониторингийн тайланг бичлээ. Тайланг танилцуулах Зөвлөлдөх уулзалтыг цагдаа, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдах ажилтан ба сургалт хариуцсан 40 мэргэжилтнийг оролцуулан зохион байгуулав.



- ▶ Монгол Улс НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит хэлэлцүүлэгт 2 удаа орж, 2015 оны 5-р сарын 5-ны өдөр НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Бүгд хурлын үеэр 150 зөвлөмжийг хэрэгжүүлэхээр үүрэг амлалт авсан билээ. Эдгээр зөвлөмжийн 21 нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах чиглэлээр өгсөн зөвлөмжүүд байдаг. ХЭҮТ нь “Хүний эрхийн төлөв байдлын ээлжит тайлан илтгэл-2019”-д дээрх зөвлөмжүүдийн хэрэгжилтийн байдал болон тулгамдаж буй асуудлын талаар мэдээлэл цуглуулан тайлан бэлтгэж НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд хүргүүллээ.

- ▶ Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчийн эрх, хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг хүргэх үүргийг хуулиар хүлээсэн мэргэжилтнүүдэд хүний эрх, жендэрийн тэгш байдал, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох стратегийн талаар суурь мэдлэг, нэгдсэн ойлголт, зайлшгүй шаардагдах ур чадварыг олгох зорилгоор “Хохирогчийг хамгаалах цогц тогтолцоо ба салбар дундын зохицуулалт” мэргэжилтнүүдэд зориулсан цөм хөтөлбөрийн гарын авлага боловсруулж, хэвлүүлээ.



- ▶ Нэг цэгийн үйлчилгээний төвд эрүүл мэндийн болон нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх стандартын төслийг боловсруулж, холбогдох төрийн байгууллагуудын 40 мэргэжилтнээр хэлэлцүүлэн сайжрууллаа. Уг стандарт нь Нэг цэгийн үйлчилгээний төвд дагаж мөрдөх стандартын нэг хэсэг болж батлагдах юм.

Стратегийн өмгөөлөл:

“Төрийн байгууллага, алба хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид учирсан хохирлыг төрөөс нөхөн төлүүлсэн жишиг тогтоох нь” стратегийн өмгөөллийг Нээлттэй нийгэм форумын санхүүгийн дэмжлэгтэй хийв. Уг өмгөөллийн эхний шатны хүрээнд эрүүгийн 3 хэргийг анхан шатны болон давж заалдах, хяналтын шатны шүүхээр амжилттай шийдвэрлүүлээд байна.



Сургалт мэдээлэл, арга зүйн хөтөлбөр

Мэргэжилтнүүдийг чадавхижуулах

- ▶ “Хохирогчийг хамгаалах цогц тогтолцоо ба салбар дундын зохицуулалт” сургалтыг Баян-өлгий, Өмнөговь, Дорнод, Хэнтий, Хөвсгөл, Өмнөговь, Өвөрхангай аймгууд болон Нийслэлийн 2 дүүргийн хамтарсан багийн 375 мэргэжилтнүүдэд зохион байгууллаа.
- ▶ Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэдтэй ажилладаг мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалтыг нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны ажилтнуудад зохион байгууллаа. Сургалтад бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд шууд үйлчилгээ үзүүлдэг төрийн болон ТББ-ын 25 мэргэжилтэн хамрагдаж хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг таних, эрт шатанд нь илрүүлэх, хохирогчийг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх ур чадварт суралцав.



Мэргэжилтнүүдийг ажлын байранд нь дагалдуулан сургав.

Нэг цэгийн үйлчилгээний 8 төвийн 75 мэргэжилтнүүдийг ажлын байранд нь дагалдуулан сургах сургалтыг 6 аймаг, 2 дүүрэгт зохион байгууллаа. Сургалтад хамрагдсан мэргэжилтнүүд кейс нээхээс авахуулаад хаах хүртэлх үе шатуудад НЦҮ-ний төвд хийгдэх ажиллагаа, бусад үйлчилгээнд холбон зуучлах, хохирогчид үзүүлэх үйлчилгээ, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг орон нутагт явуулах, төрийн байгууллагатай хамтран ажиллах, орон нутгийн бодлогод нөлөөлөх зэрэг үр чадварт суралцав.



Орон нутгийн ТББ-уудыг чадавхижуулах хүрээнд “Төсөл бичих арга зүй” сэдэвт сургалтыг Улаанбаатар хот болон орон нутгийн ТББ-ын 25 мэргэжилтнүүдийн дунд зохион байгуулж, төсөл бичих мэдлэг, үр чадвар эзэмшүүлэв. Сургалтын үр



дүнд 6 оролцогч төслийн уралдаанд оролцож шалгарсан, 7 оролцогч хөрөнгө босгох үйл ажиллагааг орон нутагтаа амжилттай зохион байгуулаад байна. Оролцогчид хаалттай онлайн групп үүсгэж харилцан мэдээлэл солилцож, туршлагаа хуваалцан ажиллаж байна.

“Сонсголгүйн боловсрол” төвтэй хамтран 21 аймгаас ирсэн 25 сонсголын бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчид анхан шатны мэдээлэл, зөвлөгөө өгөх агуулгаар сургалт зохион байгуулж, хүчирхийллийг таньж мэдэх, урьдчилан сэргийлэх мэдлэг, үр чадварыг олголоо. Сургалтад оролцсон эмэгтэйчүүд орон нутгийнхаа сургагч багшаар бэлтгэгдсэн. юм.



- ▶ “Сонсголгүйн боловсрол” төвтэй хамтран сонсгол, хараа, тулгуур эрхтний бэрхшээлтэй холимог бүлгийн 25 хүн, мөн Хараагүйчүүдийн холбоотой хамтран харааны бэрхшээлтэй 50 иргэдэд тус тус гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга зам, өөрийгөө хэрхэн хамгаалах, аюулгүйн төлөвлөгөө боловсруулах, хаана хандаж тусламж, дэмжлэг авах талаар мэдлэг, мэдээлэл өглөө. Сургалтыг явуулахдаа оролцогч тус бүрийн хөгжлийн бэрхшээлийн онцлогт нийцүүлсэн арга, аргачлалыг боловсруулж туршсан нь үр дүнтэй байсан.



Хүүхэд хамгаалал хөтөлбөр

- ▶ Холт интернешнл Олон улсын хүүхдийн байгууллага нь 2016 оноос хойш бидний үйл ажиллагааг дэмжин дараах чиглэлд хамтран ажиллаж байна. Үүнд:

Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн улмаас түр хамгаалах байранд байрлан үйлчлүүлсэн эрсдэлт бүлгийн, хүнд нөхцөлд амьдарч байгаа 46 өрхийн 55 хүүхдийн амьжиргааг дээшлүүлэх, боловсролыг дэмжих зорилгоор сар бүр тогтмол мөнгөн тэтгэмж олгож байгаа нь хүүхдийн хоол хүнс, наад захын хэрэгцээг хангах, эрүүл мэндийг дэмжихэд үнэтэй хөрөнгө оруулалт болдог. Мөнгөн тэтгэмжид хамрагдсан хүүхдүүд сургууль, цэцэрлэгт бүрэн хамрагдаж байгаа бөгөөд тэдний танин мэдэхүй болон хэл ярианы чадвар дээшилж байна.




- ▶ Мөн Холт интернешнл байгууллага нь түр хамгаалах байранд байрлаж буй хүүхдүүдийн гэр бүлийг дэмжих, мэргэжил олгох, өөрсдөө бие даан ажил хөдөлмөр эрхлэх, тогтвортой амьжиргааны эх үүсвэртэй болоход нь тусалдаг. 2019 онд уг дэмжлэгийн хүрээнд 24 эмэгтэйг цэцэрлэгийн туслах багш, гоо сайханч, тогооч, үсчин, оёдол,

эсгүүрчин зэрэг мэргэжил олгох сургалтад хамруулж, ажлын байранд холбон зуучиллаа.


- ▶ “Гэр бүл, хүүхэд залуучууд хөгжлийн газрын санхүүгийн дэмжлэгтэй “Сонгинохайрхан, Баянгол, Хан-уул дүүргийн эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж, гэр бүлтэй ажиллах нь” төслийг амжилттай хэрэгжүүллээ. Төслийн хүрээнд эрсдэлт бүлгийн 53 хүүхдэд харьяа хорооны хамтарсан багаар нь нөхцөл байдлын үнэлгээ хийлгэж, үйлчилгээг хамтран үзүүллээ.


Төслийн үр дүн:

 **13** Боловсролын үйлчилгээ


 **6** Сэтгэл заслын үйлчилгээ

 **38** Эрүүл мэндийн үйлчилгээ

 **65** Гэр бүлийн гишүүдийн уулзалт

 **10** Бичиг баримтжуулах

 **26** Сэтгэл зүйн зөвлөгөө

 **22** Эцэг эхтэй ганцаарчилсан уулзалт

“Дэмжье, Хамтдаа хөгжье” хүүхдийн оролцооны бүлэг

“Дэмжье, Хамтдаа хөгжье” хүүхдийн оролцооны бүлэг бүрдүүлэн 8 удаагийн дэмжих бүлгийн сургалтыг 25 хүүхдийн дунд амжилттай зохион байгууллаа. Хүүхдүүд сургалтад хамрагдснаар:

- ▶ Хүн бүр онцгой, цор ганц, дахин давтагдашгүй бөгөөд бие биенийхээ эрхийг хайрлан хүндлэхийн ач холбогдол:
- Бэлгийн ариун цэвэр, бэлгийн бойжилттой холбоотой өсвөр насанд тохиолддог асуудлуудын талаар мэдлэг, ойлголттой боллоо.



Эцэг эхчүүдийн дэмжих бүлэг

- Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэдтэй гэр бүлийг эрх мэдэлжүүлэх, чадавхижуулах, хувийн болон хамтын манлайллын ур чадварыг дээшлүүлэх, хүүхэдтэйгээ зөв харилцах, хүүхэд хүмүүжлийн эерэг аргад суралцуулах зорилгоор эцэг эхчүүдэд зориулсан 12 удаагийн дэмжих бүлгийг зохион байгуулсан. Эцэг эхчүүд дэмжих бүлэгт хамрагдсанаар:
- Хүний эрхийн талаарх ойлголт, мэдээлэл авч, гэр бүлийн гишүүдтэйгээ харилцдаг өөрсдийн харилцаандаа дүгнэлт хийж, нийтлэг гаргадаг алдаагаа олж харсан;



- Хүчирхийллийн шалтгаан, нөлөөлөгч хүчин зүйлсийн талаар ойлголттой болсон;
- Хүүхдийн хувийн орон зайг бий болгох нь хүүхдийн хүмүүжил, төлөвшилд ач холбогдолтойг ойлголоо.

“Эерэг хандлагыг төлөвшүүлэх нь” дэмжих бүлэг



Зан үйлийг өөрчлөх, эерэг зөв хандлагыг төлөвшүүлэх зорилго бүхий дэмжих бүлгийн 8 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 160 эцэг эхчүүдийг хамрууллаа. Үр дүнд эцэг эхчүүд өөрт тулгамдаж буй асуудлаа тодорхойлж, хүлээн зөвшөөрч, эрсдэлт зан үйлээ өөрчлөх сэдэл төрж эхэлсэн. Сургалтыг “SASA!” аргачлалыг ашиглан хувь хүний өөрчлөлтөд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор архины хордлого тайлах эмийн эмчилгээ болон урт хугацааны сэтгэл заслын үйлчилгээтэй хослуулан явуулж байна.

Нутгийн хамт олны хөгжил хөтөлбөр

Орон нутгийн салбарууд:

- **Дархан-Уул** аймаг дахь салбар нь хүчирхийлэл үйлдэгчийн Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэрэгжилтийн байдалд үнэлгээ хийж, тайлангаа аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд танилцууллаа.
- **Өвөрхангай** аймаг дахь салбар нь “Орон нутагт хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулахад хүүхэд хамгааллын үйлчилгээг сайжруулах” төслийг Аймгийнхаа гэр бүл, хүүхэд залуучууд хөгжлийн газартай хамтран хэрэгжүүллээ. Төслийн үр дүнд:
 - Аймгийн хэмжээнд хүүхдийн эсрэг хүчирхийллийн байдал, шийдвэрлэх арга замыг тодорхойлсон судалгааны багцтай болсон.
 - Сургуулийн нийгмийн ажилтнууд, багийн нийгмийн ажилтнуудад “шинэ арга зүйд” суралцах сургалтыг зохион байгуулан, мэргэжилтнүүдийн хамтын ажиллагааг сайжруулахад нөлөөлсөн.
- **Баянхонгор** аймаг дахь салбар нь: Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран Баян-Овоо, Баацагаан, Баянцагаан, Баян-Өндөр, Шинэжинст, Гурванбулаг,



Бууцагаан, Хүрээмарал, Баянбулаг, Бөмбөгөр, Жинст, Богд, Баянлиг, Баянговь, Өлзийт сумдад тус тус ажиллаж, хамтарсан багийн гишүүдэд арга зүйн зөвлөгөө өгч, иргэдэд хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө, сэтгэл зүйн зөвлөгөө өгч, сургалт зохион байгууллаа. Үүнд:


- ЕБСургуулийн 463 сурагчдад сургалт, мэдээлэл өгч ажилласан.



- “Эх үрсийн баяр”-ыг тохиолдуулан “Стрийт арт” гар зургийн уралдаан зохион байгууллаа. Уралдаанд 4 сургуулийн 10 багийн нийт 64 сурагчид оролцлоо. Уг зургийн уралдаан нь хүүхдийн дотоод ертөнц, авьяас чадвараа нээн хөгжүүлэх, үзэл бодлоо чөлөөт, бүтээлч байдлаар илэрхийлэх, багаар хамтран ажиллангаа хүүхдүүд бие биедээ хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдээллийг олгосон үр дүнтэй үйл ажиллагаа болсон.

Түр хамгаалах байруудын сүлжээ хөтөлбөр

Түр хамгаалах байранд нийт 138 хүнийг байрлуулан үйлчилгээ үзүүллээ. Үйлчлүүлэгчдийн 53,6% ийг хүүхдүүд эзэлж байна.



Түр хамгаалах байранд байрласан хүүхэд, эмэгтэйчүүдийн аюулгүй байдлыг нь хамгаалахын зэрэгцээ дараах цогц үйлчилгээг үзүүллээ:



Анхан шатны суурь хэрэгцээ



Чанартай, амин дэмтэй хоол хүнсээр хангасан



Зөв дадал хэвшил



Хамгаалах байрны цэвэрлэгээ үйлчилгээ, эрүүл орчин бүрдүүлсэн

138

	Тасралтгүй боловсролын үйлчилгээ:	32 ХҮН
	Сэтгэл зүйн зөвлөгөө	109 ХҮН
	Бүлгийн сэтгэл засал	87 УДАА
	Гэртэй болгосон	2 ХҮН
	Эрүүл мэндийн үйлчилгээ	120 ХҮН
	Бичиг баримтжуулах үйлчилгээ	24 ХҮН
	Ажилд холбон зуучилсан	14 ХҮН
	Хуулийн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээ	112 ХҮН



Түр хамгаалах байранд хүүхдийн дэмжих бүлэг болон эмэгтэйчүүдийн дэмжих бүлгийн уулзалтыг 7 хоногт 1-2 удаа тогтмол зохион байгуулдаг. Хүүхдийн дэмжих бүлэг 35 удаа, эмэгтэйчүүдийн дэмжих бүлэг 52 удаа зохион байгуулсан байна.



Сурталчилгаа

Хүрч очих үйлчилгээ:

Нийслэлийн алслагдсан хороод болох СХД-ийн 22, 42-р хороо, БЗД-ийн 9,17, 19, 22, 24-р хороо, Чингэлтэй дүүргийн 12-р хороодод хүрч очих үйлчилгээ үзүүлээ.

Хүрч очих үйлчилгээний баг нь хуульч, эмч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийн бүрэлдэхүүнтэй ажиллаж, хорооны иргэдэд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг түгээж, анхан шатны эрүүл мэндийн үзлэгт хамруулан, хуулийн болон сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө өгөв.



Үр дүн:



Хүрч очих үйлчилгээ үзүүлэх явцад эрсдэл өндөр 12 эмэгтэй, бэлгийн хүчирхийлэлд өртсөн бага насны 6 хүүхдийг илрүүлж хамгаалалтад авсан байна.



Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян:


Энэ жилийн аяныг “ОйлГОЁ ХҮНдэлье” уриан дор тэмдэглэн өнгөрүүллээ. Аянд төрийн болон төрийн бус 123 байгууллагууд нэгдсэн.



Аяны хүрээнд Гэр бүлийн радио 104.5-тай хамтран гэр бүлийн эерэг харилцааг сурталчилсан 4 цуврал подкаст бүтээж, 12 удаагийн давтамжтайгаар нэвтрүүллээ. Уг подкастыг радиогийн подкаст суваг, www.1045.mn, soundcloud, itunes-т тус тус байршуулж, онлайн сувгаар түгээсэн нь нийт 21,000 сонсогч, хэрэглэгчдэд хүрсэн.

<p>Таны толгойд юу байна? #17 ЭР ХҮН Ч ГЭСЭН УЙЛДАГ</p> <p>86 Total number of plays</p>	<p>Таны толгойд юу байна? #18 ХӨГЖИЛТЭЙ БАЦХАН ҮРСЭЭСЭЭ ХҮҮХЭД НАСНЫ НЬ БҮҮ БУЛААГААРАЙ</p> <p>80 Total number of plays</p>
<p>Таны толгойд юу байна? #16 ХЭН НЭГИЙГ ХАМГААЛАХАД ТАНЫ ОРЛОЦОО ЧУХАЛ</p> <p>119 Total number of plays</p>	<p>Таны толгойд юу байна? #14 ХҮЧИРХИЙЛЭЛД ЯЛАГЧ БАЙХҮЙ</p> <p>103 Total number of plays</p>

UB Life сайттай хамтран эрчүүдийг эерэг харилцаанд уриалан дуудсан видео шторк бүтээж, дохионы хэлний орчуулгатайгаар Ub.life сайт, Ub.life-ийн социал хуудсууд, Urug.mn-ийн социал хуудсуудаар түгээсэн нь нийт 16136 хүнд хүрсэн байна.



Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйлчилгээний зураглал боловсруулан хэвлүүлж, орон нутгуудад үйл ажиллагаа явуулж буй Нэг цэгийн үйлчилгээний төвүүдэд хүргүүлээ.

Хүний эрхийн нээлттэй өдөрлөг

Олон улсын хүний эрхийн өдрөөр ТББ –ууд нэгдэн зохион байгуулсан “Эрхийнхээ төлөө нэгдэцгээе” сэдэв дор УДБДТеатрын гадна талбайд Зургийн үзэсгэлэн гаргаж, иргэдэд үнэ төлбөргүй хуулийн болон сэтгэл зүйн зөвлөгөө өгч, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдээлэл түгээж ажиллав.



Хэвлэмэл материал:

Цагаан тууз, танилцуулга, “Ажлын байран дэхь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх” мэдээллийн хуудас, “Хүүхдийн эрх” хөзрөн карт, “Таньд сонголт бий” даван туулагчдад зориулсан гарын авлага (Англи, монгол) -ыг тус тус хэвлүүлж, нийт 38.000 гаруй хүнд хүргэж ажиллалаа.



Чадавхи бэхжүүлэх хөтөлбөр

Дотоод хамтын ажиллагаа:

- Монфемнэт сүлжээний гишүүн;
- Хүний эрхийн ТББ-уудын форумын гишүүн;
- Ажлын байран дахь бэлгийн дарамтын эсрэг эвслийн гишүүн;
- Бүх нийт боловсролын төлөө Иргэний нийгмийн Үндэсний эвслийн гишүүн;
Хүний наймааны эсрэг ТББ-дын сүлжээний гишүүн.

Гадаад харилцаа, хамтын ажиллагаа

- ▶ GlobalRightsforWomen байгууллагын ахлах зөвлөх Helen Rubenstein нь тус төвд ОУ-ын зөвлөхөөр ажилладаг. Тэрээр ХЭҮТ-ийн хамт олонд гэр бүлийн хүчирхийллийн сүүлийн үеийн онол, хүчирхийлэл үйлдэгч эрчүүдийн зан үйл нөлөөлөх хөтөлбөрүүдийн сайн туршлага, гэр бүлийн хүчирхийлэлд олон нийтийн зүгээс зохион байгуулалтай хариу арга хэмжээ авах аргачлал зэрэг шинэ мэдлэг, ур чадвар олгосон сургалт зохион байгууллаа.



Олон улсын нийгмийн үйлчилгээний байгууллага (ISS)-ын Ази Номхон далайн бүсийн сүлжээ хариуцсан бүсийн хөгжлийн менежер Мартин Лай Монгол улсад хүрэлцэн ирж, улс дамнасан нийгмийн ажлын үйлчилгээний арга зүйн сургалт зохион байгууллаа.

- ▶ АНУ-д үйл ажиллагаа явуулдаг Х.Эрдэнэчимэг ахлагчтай Мандухай цирк нь манай төвийн Итгэлтэй утасны үйлчилгээг жил бүр санхүүжүүлдэг бөгөөд энэ жил 1500\$ хандивлалаа.

Тэд манай төвийн түр хамгаалах байрны үйлчлүүлэгчдэд зориулан циркийн үзүүлбэрээ тоглож, Завхан аймгийн 11 сумдад аялан тоглолт хийхийн зэрэгцээ нутгийн иргэдэд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл түгээж ажилласан.



- ▶ Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын 13 хүний бүрэлдхүүнтэй баг манай байгууллагаар зочиллоо. Төлөөлөгчид Монгол улсын төр болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг батлуулахад иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо, хүчирхийллийн хохирогчдод үзүүлж буй үйлчилгээний талаарх харилцан туршлага солилцов.




- ▶ НҮБ-ын Хүн амын сангаас зохион байгуулсан Филиппин Улсад туршлага судлах аялалд ХЭҮТ-ийн захирал Н.Арвинтариа оролцсон. Тус улсын жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх зүгн орчинтой танилцаж, нийт 10 байгууллагын туршлага судаллаа.




- ▶ 2019 оны 9 дүгээр сарын 25-наас 27-ны өдрүүдэд Тайландын нийслэл Бангкок хотноо зохион байгуулагдсан Ази, Номхон далайн бүс нутгийн эмэгтэйчүүдийн сангууд, феминист хандивлагч байгууллага, тэтгэлэг авагчдын олон улсын хуралд тус төвийн төлөөлөл оролцлоо.
- ▶ 2019 оны 11-р сарын 5-8 ны өдрүүдэд Тайван улсын Kaohsiung хотод зохион байгуулагдсан "Эмэгтэйчүүдийн Хамгаалах Байрны Дэлхийн 4-р Чуулган" нд манай төвийн төлөөлөгчид оролцож, дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн 1500 гаруй төлөөлөгчидтэй жендэрт суурилсан хүчирхийллийг таслан зогсооход хувь нэмрээ оруулж буй туршлагаа хуваалцаж, хамтын ажиллагаагаа бэхжүүллээ.




1995-2019 он хүртэлх хугацаанд нийт 21.994 хүн ХЭҮТөвд хандан үйлчлүүлсэн. Энэ тоо нь зөвхөн үйлчлүүлэгчийг анх удаа хандахад бүртгэсэн тоо бөгөөд 1 үйлчлүүлэгч дунджаар 4-8 удаа давтан хандаж зөвлөгөө үйлчилгээ авдаг.




Төвийн үйлчлүүлэгчдийг хүйсээр нь авч үзвэл:



Төвийн үйлчлүүлэгчдийн дийлэнх хувийг 18-34 насныхан эзэлж байна.



10/8 Нөхөр, хамтран амьдрагчийнхаа зүгээс хүчирхийлэлд өртсөн байна.



4/1 амиа хорлох оролдлого хийж байсан.





138
Аюулгүй
байдлын
хамгаалалт

421
Сэтгэл зүйн
үйлчилгээ

678
Эрх зүйн
туслалцаа

124
Хүүхэд
хамгаалал

257
Холбон
зуучлах

221
Эмнэлгийн
тусламж,
үйлчилгээ

352
Нийгмийн
ажлын
үйлчилгээ




1150
хүн үйлчлүүлсэн.




754
Итгэлтэй утас


Хуулийн зөвлөгөө, эрх зүйн туслалцаа



Нийт орлого:
521,588,124 төг



Нийт зарлага:
477,829,605 төг



Бидний үйл ажиллагааг дэмжин хамтран ажилласан байгууллага, хамт олон, хувь хүмүүстээ БАЯРЛАЛАА
 Hereby we would like to extend our gratitude to organizations, colleagues and individuals who have supported and collaborated with us.



“Хайрын будаа”
ТББ

Wasabies охидын
хамтлаг

Шинэ толь
групп

Таван тивийн
андууд ТББ

Аз жаргалын эхлэл
Цахим хуудас

**ХУВЬ ХҮМҮҮС
INDIVIDUALS:**

- Б.Ариунтуул
- О.Байгалмаа
- Б.Ариунсанаа
- Х.Сүрэн
- Г.Булгантамир
- Т.Чимгээ
- Б.Бямбасайхан
- Ц.Ганзориг
- Д.Нарангоо
- Р.Баясгалан
- Б.Цацрал
- Ариунжаргал
- Ш.Зулгэрэл
- Цэвэгмид
- Азжаргал
- Н.Золцэцэг
- Т.Энх-Амгалан
- Э.Жаргалмаа
- Х.Эрдэнэчимэг
- Synthia M.Horne
- Төгс-Оюун
- Э.Хандармаа
- Д.Эрдэнэцогт
- О.Гэрэлээ
- Engelbert

УДИРДАХ ЗӨВЛӨЛ:

Удирдах зөвлөлийн дарга
Б.ОЮУНБИЛЭГ

Удирдах зөвлөлийн гишүүд:

- К.АЙНАГҮЛ
- Ц.АЛТАНЦЭЦЭГ
- Х.НУРЖАН
- М.ХОРОЛСҮРЭН
- Ч.СОСОРМАА
- Н.ТУНГАЛАГ
- Г.ЦЭРЭННАДМИД
- Д.ЭНХЖАРГАЛ

ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ:

Хянатын зөвлөлийн дарга
Ц.ОЮУН

Гишүүд:

- С.ЦЭРЭНПҮРЭВ
- Н.НАРАНЦЭЦЭГ

АЖЛЫН АЛБА

Н.АРВИНТАРИА

Захирал

С.БАЙГАЛМАА

Хөтөлбөрийн менежер

З.УНДРАХ

"Хамгаалах байруудын сүлжээ хөтөлбөр"-ийн зохицуулагч

М.МӨНХСАРУУЛ

Гадаад харилцааны ажилтан

С.МӨНХЖАРГАЛ, Н.БОЛОРМАА

Нягтлан бодогч

Ч.ОДОНЧИМЭГ

Хуулийн зөвлөгч

Д.САНЧИР

Хуулийн зөвлөгч

Ц.ДАВААСҮРЭН, Д.ОЮУНДАРЬ

Сэтгэл зүйч

О.НЯМБАЯР

Нийгмийн ажилтан

Б.ДОЛЖИНСҮРЭН

Халамжлагч ажилтан

Д.ДОЛГОРСҮРЭН

Халамжлагч ажилтан

Б.ДАВААСАМБУУ

Жолооч-нярав



ONLINE **17,129** Like **150%** Өсөлтийн хувь



Хүчирхийллийн эсрэг үндэсний төв



Хамгаалах байр



Орон нутаг дахь салбар



Нэг цэгийн үйлчилгээний төв

ХҮЧИРХИЙЛЛИЙН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ТӨВ

ХАЯГ: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, Бага тойруу 40-р байр 03, 06 тоот

Утас/Факс:

+976-70119949

Зөвлөгөө өгөх утас:

+976-96490505

И-мэйл хаяг:

mongolcav@gmail.com

Вэб сайт:

www.safefuture.mn

www.facebook.com

Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ/
National center against violence Mongolia

Шуудангийн хайрцаг:

Чингэлтэй 46, Улаанбаатар

